



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар

9/357

Улаанбаатар хот

Г Сонгинохайрхан дүүргийн Боловсролын
хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн есдүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 11 нэр төрлийн нийт 15,752,084.40 (арван таван сая долоон зуун тавин хоёр мянга наян дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс (А.Дүүдээ)-т зөвшөөрсүгэй.

2. Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 1 нэр төрлийн нийт 2,535,500.00 (хоёр сая таван зуун гучин таван мянга таван зуун) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөх, 8 нэр төрлийн 2,833,890.00 (хоёр сая найман зуун гучин гурван мянга найман зуун ерэн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, 2 нэр төрлийн 10,382,694.40 (арван сая гурван зуун наян хоёр мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 90,000.00 (ерэн мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 27,000.00 (хорин долоон мянга) төгрөгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс (А.Дүүдээ)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В. Оюумаа

В.ОЮУМАА

1050501081

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны дүгээр сарын 15-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	УХХХК-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Принтер өнгөт	5	ш	1	489,900.00	489,900.00	489,900.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
2	Ухаалаг самбар	7	ш	1	6,883,694.40	6,883,694.40	6,883,694.40	-	эвдэрсэн	актлах	-	50,000.00	50,000.00
3	Дэлгэц проектор	7	ш	1	259,990.00	259,990.00	259,990.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
4	Зөөврийн компьютер	5	ш	1	2,535,500.00	2,535,500.00	2,535,500.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
5	Хэвлэгч 2021	3	ш	2	450,000.00	900,000.00	900,000.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
6	Вэб камер	3	ш	1	105,400.00	105,400.00	105,400.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
7	Принтер 3010	3	ш	1	445,720.00	445,720.00	445,720.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
8	Дэлгэц 2023	3	ш	1	352,880.00	352,880.00	352,880.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
9	Суурин компьютер	5	ш	2	1,749,500.00	3,499,000.00	3,499,000.00	-	эвдэрсэн	актлах	-	40,000.00	40,000.00
Машин тоног төхөөрөмжийн дүн					11	15,472,084.40	15,472,084.40					90,000.00	90,000.00
2.Тавилга эд хогшил													
1	Сандаг түшлэгтэй	7	ш	1	120,000.00	120,000.00	120,000.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
2	Сандаг	2	ш	4	40,000.00	160,000.00	160,000.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
Тавилга, эд хогшилийн дүн					5	280,000.00	280,000.00					-	-
Нийт дүн						15,752,084.40	15,752,084.40					90,000.00	90,000.00
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө						10,382,694.40							
Татан төвлөрүүлэх						2,535,500.00							
Устгах хөрөнгө						2,833,890.00							
Худалдсанаас олох орлого						90,000.00							
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						27,000.00							